



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/23

Улаанбаатар хот

Г Зохион байгуулалтын арга хэмжээ  
авч ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2020 оны 30, 62, 64 дүгээр тогтоол, 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Улсын Онцгой комиссын 06 дугаар тогтоол, Нийслэлийн Онцгой комиссийн 08 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, 166, 168, 268, 369 дүгээр захирамжуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс орны хэмжээнд онцгой нөхцөл байдал үүсч МУ-ын ЗГ-ын шийдвэрээр коронавируст халдварт (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, халдвартын эрсдлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг найдвартай хангаж, оновчтой зөв зохион байгуулах зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллахыг байгууллагын орлогч дарга нар, хэлтэс, алба, нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

1.1 Хурал зөвлөгөөн хийх, үүрэг чиглэл өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг аль болох цахим хэлбэрт шилжүүлэн хэрэгжүүлж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Ч.Шинэчимэг/-т ;

1.2 Дээрх нөхцөл байдалтай уялдуулан Захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчдын ажил үүргийг онцгой нөхцөл байдлын үед уян хатан байдлаар зохицуулж шаардлагатай тохиолдолд дайчлах, татан оролцуулах, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/, Захиргааны ахлах мэргэжилтэн /Г.Энхтуяа/-д ;

1.3 НЗЗ-ны байруудад ажиллах үйлчилгээний албан хаагчдаар ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол, хариуцлагатай хийлгэж ажлын горимыг уян хатан байдлаар тогтоон, шаардлагатай нөхцөлд дуудаж ажиллуулах зохицуулалтыг хийж ажиллахыг Орлогч дарга /С.Доржсүрэн, Б.Галмандах, Ч.Однасан/ нар, Байр ашиглалтын алба /Г.Батзаяа/, Үйлчилгээний алба /М.Алтантуяа/, байр хариуцсан менежерүүдэд ;

1.4 Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд ажиллах албан хаагчдын ажлын цагийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан хуваарь /10:00 – 16:00/-ийн дагуу ажиллуулахыг Орлогч дарга /Б.Галмандах/, Байр хариуцсан менежер /Б.Туяасайхан, Б.Номин-Эрдэнэ, Д.Оюунтуяа/ нарт ;

1.5 Ажлын байрны ариутгал, халдвартгүйтгэлийг хийлгэх, албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай оношлогоо болон эрүүл ахуйн тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл (биений халуун хэмжигч, дараалтын аппарат, шингэн саван, гар хатаагч, гар арчих цаас, гар ариутгалын бодис, амны хаалт, агааржуулагч болон саармагжуулах бусад материал гэх мэт)-ийн хангалтыг бүрдүүлж ажиллахыг Ерөнхий няглан бодогч /Х.Цогзолмаа/-д ;

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр хангаж ажиллахыг Орлогч дарга /С.Доржсүрэн, Ч.Однасан, Б.Галмандах/, Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

1150500045

